



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 9/26

Номгон

Баянхонгор аймгийн тэмээчдийн
зөвлөгөөн, аварга шалгаруулах хурдан
тэмээний уралдааны шалгаруулах ажлын
хэсэг томилж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймгийн Тэмээчдийн зөвлөгөөн, аварга шалгаруулах хурдан тэмээний уралдааныг 2026 оны 01 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд Баян-Өндөр сумд зохион байгуулсугай.

2.Хурдан тэмээний уралдаан болон тэмцээнийг шалгаруулах ажлын хэсгийг нэгдүгээр, арга хэмжээний удирдамжийг хоёрдугаар, зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Үйл ажиллагаанд зарцуулах 20.000.000 (Хорин сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр
сарын 13-ны өдрийн 146 дугаар
захирамжийн 01 дүгээр хавсралт

ХУРДАН ТЭМЭЭНИЙ УРАЛДААН БОЛОН ТЭМЦЭЭНИЙГ
ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

1.Хурдан тэмээний уралдаан шалгаруулах ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Мөнхтулга

Монголын тэмээн соёл спорт уралдааны холбооны
нарийн бичгийн дарга

Гишүүдэд:

Н.Батнасан

Баян-Өндөр сумын Засаг даргын Орлогч

Э.Наранбаатар

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын Мал эмнэлгийн тасгийн
дарга

Б.Мөнхтуул

Хүүхэд гэр бүл, хөгжил, хамгааллын газрын Хүүхэд
хамгаалал кеис менежментийн асуудал хариуцсан
мэргэжилтэн

Д.Энхтөр

Баянцагаан сумын ЗДТГ-ын Мал аж ахуйн
менежмент, малын үржил бүртгэл мэдээллийн
асуудал хариуцсан мэргэжилтэн

Б. Одгэрэл

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын Хүүхэд гэр бүл
хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Ц. Сарангэрэл

Баян-Өндөр Сумын Тэмээчдийн холбооны дарга

2.Тэмцээн шалгаруулах ажлын хэсэг (Ганган хос, Шилмэл буур, ат, ингэ, ур чадвар)

Ажлын хэсгийн ахлагч:

М.Эрхэмбаяр

Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

Гишүүдэд:

Д.Бумбаяр

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналтын улсын байцаагч

Д.Энхтөр

Баянцагаан сумын ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасгийн
дарга

П.Ундармаа

Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын Мал
үржлийн ажил үйлчилгээний, хяналтын Улсын байцаагч

Х. Жигмэддорж

Баян-Өндөр сумын Ахмад тэмээчин

Б.Мөнхтулга

Монголын тэмээн соёл спорт уралдааны холбооны
нарийн бичгийн дарга

Нарийн бичгийн дарга:

Б.Тогообаатар

Баян-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
дарга

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр
сарын 15-ны өдрийн 4/дк дугаар
захирамжийн 6 дугаар хавсралт



**БАЯНХОНГОР АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ХУРДАН ТЭМЭЭНИЙ УРАЛДААН, АЙМГИЙН
ТЭМЭЭЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ
УДИРДАМЖ**

Нэг.Зөвлөгөөн, наадмын зорилго.

Тэмээн сүргийнхээ үүлдэр угсааг сайжруулах, тоо толгойг өсгөх, тэмээчид, малчдын туршлага солилцуулах, тэдний хөдөлмөрийг үнэлэх, алдаршуулах, гадаад дотоодын жуулчдыг татах, олон түмнийг цэнгээн баясгахад оршино.

Хаана болох: Баянхонгор аймаг, Баян-Өндөр суманд 2026 оны 01 дүгээр сарын 15-16 өдрүүдэд

Оролцох бүрэлдэхүүн: Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Аймгийн Засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Баян-Өндөр сумын тэмээчдийн холбоо, сумдын ЗДТГ, тэмээчид, малчид, ХХААХҮЯ-ны эрдэмтдийн төлөөлөл, сумдын удирдлага, мэргэжилтнүүд

Зохион байгуулалт: Баянхонгор аймгийн сум тус бүр нэг баг, бусад аймгууд тус бүр нэг баг болж оролцоно.

-Баг нь 5-аас доошгүй гишүүнтэй байх ба багийн ахлагч нь тухайн аймаг, сумаас хариуцаж ирсэн хүн байна. Багийн бүрэлдэхүүнд сумын ХАА-н тасгийн мэргэжилтэн 1, тэмээчин 3-аас доошгүй оролцоно.

-Тэмээчдийн зөвлөгөөн, наадмын төрөл тус бүрд багаараа оролцох бөгөөд наадмын нээлтэд өөрийн багийн өвөрмөц байдал, тэмээчдийн алдар гавьяа, тэмээний сүр жавхланг илтгэсэн жагсаалаар оролцоно.

-Зөвлөгөөнд оролцож буй аймаг, сумууд тэмээний гаралтай бараа, бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаа гаргана.

-Зөвлөгөөн, наадамд оролцогчид замын зардал, байр, хоолны зардлаа өөрсдөө хариуцаж, аюулгүй байдлаа хангаж оролцоно.

-Зохион байгуулж байгаа аймаг байраар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Шүүгчдийн бүрэлдэхүүн: Баянхонгор аймгийн "Ламын Гэгээний Улаан" тэмээчдийн холбоо, Баян-Өндөр сумын тэмээчдийн холбоо, Баян-Өндөр сумын ХААТ-н мэргэжилтнүүд

Шалгаруулалт, шагналын сан: Тэмээчдийн зөвлөгөөн , наадмын үйл ажиллагаа уралдаан тэмцээнд оролцсон байдал гаргасан амжилтыг оноогоор үнэлж багуудыг байр эзлүүлэн шагнаж урамшуулна.

Жич: Уралдаан тэмцээнд амжилттай оролцож байр эзэлсэн хүмүүсийг хувийн амжилтаар нь шагнаж урамшуулахын дээр ажил, хөдөлмөрөөрөө шалгарсан зарим тэмээчдийг төр засаг, аймаг, орон нутаг, төрийн бус байгууллага, ААН, иргэдээс ивээн тэтгэсэн шагнал урамшуулалд хамруулна.

Зохион байгуулах уралдаан тэмцээн, шалгуур:

-“Атан” тэмээний уралдаан (Унаач нь 16 наснаас дээш, хамгаалалтын хувцас хэрэгсэлтэй,хүүхдийн гэнэтийн ослын даатгалд хамрагдсан нотлох баримт бичиг, иргэний үнэмлэхтэй ирнэ)

-“Тайлга”-ны уралдаан (Унаач нь 16 наснаас дээш, хамгаалалтын хувцас хэрэгсэлтэй, хүүхдийн гэнэтийн ослын даатгалд хамрагдсан нотлох баримт бичиг, гадаад паспорт заавал авчирна)

-“Тором”-ны уралдаан (Унаач нь 15 наснаас дээш, хамгаалалтын хувцас хэрэгсэлтэй,хүүхдийн гэнэтийн ослын даатгалд хамрагдсан нотлох баримт, гадаад паспорт, эцэг эхийн зөвшөөрлийн бичиг заавал авчирна)

Жич: Унаач нь заасан нас хүрсэн байх ёстой хүрээгүй бол унуулахгүй байхыг анхаарна уу!!! (Хувийн дугаарын хураамж төлж бүртгэлд хамрагдсан байна)

-Тэмээтэй багийн буухиа (3 хүний гишүүнтэй) Уралдааны тэмээг бүртгүүлэхдээ зохион байгуулагчдаас дугаар авна.

“Шилмэл буур”, “Шилмэл ат”, “Шилмэл ингэ” шалгаруулах (Мэргэжлийн комисс шалгаруулна)

Тайлбар: Шилмэл атыг уналга эдэлгээнд сургасан байдлыг голлох үзүүлэлт болно.

-“Тэмээтэй ганган хос” шалгаруулах тэмцээн (Үзэгчдийн саналыг үндэслэн ажлын хэсэг шалгаруулна)

-Малын гаралтай бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа (Сумын нийлбэр оноонд нөлөөлнө)

Уралдаан тэмцээнд оролцож буй сумууд хувийн бэлтгэл (Хоол унд, хөнжил пүүгээ, тохош, буйл, бурантаг,хэц гадас, уяа, сур гэх мэтийг сайтар хангаж оролцох)

ЗӨВЛӨГӨӨН, НААДМЫН ХӨТӨЛБӨР

2026 оны 01 дүгээр сарын 15 нд

09:00 Хурдан Буухиа гараанд мордоно.

10:00 Үзэсгэлэн худалдаа гаргах (оролцогч баг бүрээс 5-аас дээш)

10:30 Хурдан буухиа барианд орох

11:00-13:00 Нээлтийн парад

13:30-15:30 Хурдан ат гараанд мордох барианд орох

14:00-15:00 Шилмэл буур, Ингэ, шалгаруулах

16:00-19:00 Тэмээчдийн баярын хурал, хүлээн авалт

17:00-18:30 Ур чадварын тэмцээн

20:00 Урлагийн арга хэмжээ, дуудлага худалдаа

2026 оны 01 дүгээр сарын 16-нд

09:30 Хурдан тайлаг гараанд мордоно.

10:11 Ганган хос шалгаруулах

11:00 Хурдан тайлаг барианд орох

11:30-12:30 Шилмэл ат шалгаруулах

13:00-14:00 Хурдан тором гараанд мордох барианд орох

15:30-22:00 Хаалт, шагнал гардуулах, үдшийн цэнгүүн

Жич: Унаач хүүхдийн нас 16-аас дээш байна.

Хурдан тэмээний уяачид, унаач нар нь уралдааны замд зориулалт бус хэрэгсэл хэрэглэхгүй.

Жишээ нь: цахилгаан бороохой, гинжин ташуур шанаадах, бурантагдах, илт хаших гэх мэт.

Тэмээчдийн баяр, зөвлөгөөнтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Аймгийн тэмээчдийн холбоо (89119289, 88030492) дугаараас лавлана уу.

.....оОо.....

Аймгийн Засаг даргын 1996 оны 6 дүгээр
сарын 13-ны өдрийн 42.26 дугаар
захирамжийн 2.3 дугаар хавсралт



ТЭМЭЭЧДИЙН АЙМГИЙН ЗӨВЛӨГӨӨН,
НААДМЫН ЗАРДЛЫН ТООЦОО.

№	Тэмээний төрөл	1-р байр	2-р байр	3-р байр	4-р байр	5-р байр	Нийт
1	2	3	4	5	6	7	8
1	Хурдан Ат	3,000,000	2,500,000	2,000,000	1,800,000	1,500,000	10,800,000
2	Өсвөр нас	3,000,000	2,500,000	2,000,000	1,800,000	1,500,000	10,800,000
3	Хурдан тором	3,000,000	2,500,000	2,000,000	1,800,000	1,500,000	10,800,000
4	Шилмэл буур	1,000,000	800,000	600,000	-	-	2,400,000
5	Шилмэл ингэ	1,000,000	800,000	600,000	-	-	2,400,000
6	Шилмэл ат	1,000,000	800,000	600,000	-	-	2,400,000
7	Сайхан тэмээтэй хос	1,000,000	800,000	600,000	-	-	2,400,000
8	Тэмээчдийн ур чадварын тэмцээн /буйл зорох, бурантаг томох/	500,000	300,000	200,000	-	-	1,000,000
9	Буухиа уралдаан	2,000,000	1,500,000	1,000,000			4,500,000
10	Үзэсгэлэн худалдаа	500,000	300,000	200,000			1,000,000
11	Телевизийн бичлэг						3,000,000
12	Аннос			2 ш*500,000			1,000,000
13	Медаль			51ш*68,000			3,468,000
14	Өргөмжлөл			51ш*19,000			969,000
15	Цулбуур			30ш*100,000			3,000,000
16	Ивээн тэтгэгчдийн гар цайлгах			32ш*50,000			1,600,000
17	Дурсгалын зүйл			51ш*40,000			2,040,000
18	Унаач хүүхдийн шагнал			15ш*30,000			450,000
19	Багийн оролцооны шагнал						1,000,000
20	Бусад зардал						7,000,000
Шагналын сан							48,500,000
Нийт дүн							72,027,000

Боловсруулсан. Баянхонгор аймгийн "Ламын Гэгээний Улаан" тэмээчдийн
холбооны нарийн бичгийн дарга Б. Мөнхтулга

Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр
сарын 13-ны өдрийн 7/26 дугаар
захирамжийн 03 дугаар хавсралт



ТЭМЭЭЧДИЙН АЙМГИЙН ЗӨВЛӨГӨӨН, НААДМЫН ЗАРДЛЫН ТООЦОО.

№	Тэмээний төрөл	1-р байр	2-р байр	3-р байр	4-р байр	5-р байр	Нийт
1	2	3	4	5	6	7	8
1	Хурдан Ат	3,000,000	2,500,000	2,000,000	1,800,000	1,500,000	10,800,000
2	Өсвөр нас	3,000,000	2,500,000	2,000,000	1,800,000	1,500,000	10,800,000

_____оОо_____